ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23. № 3/357.

танай ____________-ны №____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ХАРЪЯА УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЗАХИРАЛ С.ЗУЛПХАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ЗГХЭГ-ийн харъяа Удирдлагын академийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл**

ЗГХЭГ-ийн харъяа Удирдлагын академийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

ЗГХЭГ-ийн харъяа Удирдлагын академийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2017\0224SAG35.Docx

075457

# ЗГХЭГ-ЫН ХАРЬЯА "УДИРДЛАГЫН АКАДЕМИ"-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:**


Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор:Ц.Наранчимэг
Утас:261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885
Цахим хаяг:
Sambuunyamya@audit.gov.mn

Аудитор:Б.Баярмаа
Утас: 260512
Цахим хаяг:
bayarmaab@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг**: Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, УБ-46
**Байршил**: Чингэлтэй дүүрэг
**Цахим хуудас**: www.audit.mn


2017 оны 02 дугаар сар

**2016 оны 2 дугаар сар**

## АГУУЛГА


1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагынзорилго,үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Шилэн дансны мэдээлэл
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Шилэн дансны мэдээлэл
10. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
11. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
12. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
13. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
14. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
15. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
16. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
18. Зөвлөмж
19. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Удирдлагын Академи"-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/2/СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

"Удирдлагын Академи"-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

" Удирдлагын Академи "-ийн удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь хөндлөнгийн аудитын байгууллагын үүрэг юм.

" Удирдлагын Академи "-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25–ны хооронд хийхээр төлөвлөн "Нью диил Аудит" ХХК-ийн захирал, аудитор Э.Эрдэнэбат ахалж, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Эрхэмбаяр нар гүйцэтгэв. /ТАБ-СТА-А-8/

" Удирдлагын Академи "-ийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 23-нд "Нью диил Аудит" ХХК-д албан тоотоор ирүүлсэн.

"Нью диил Аудит" ХХК нь аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд " Удирдлагын Академи "-ийн удирдлагад гардуулна.

## Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

"Удирдлагын Академи"-ийн удирдлага нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Улсын секторын нягтлан бодох тухай хууль", Боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

## Байгууллагын зорилго,үйл ажиллагаа:

"Удирдлагын Академи" нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор Төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нийтийн албан хаагчдыг сургах, давтан сургах, нийтийн албаны хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах үүрэг бүхий Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдсан.

"Удирдлагын Академи"-ийн эрхэм зорилго нь "Манлайлан удирдах чадвартай удирдах ажилтныг бэлтгэх, удирдахуйн зангилаа асуудлаар судалгаа хийх, зөвөлгөө өгөх ажлыг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинжлэх ухааны орчин үеийн онол-арга зүйн түвшинд гүйцэтгэх" гэж тодорхойлсон байна

Үндсэн үйл ажиллагаа нь ЗГХЭГ-аас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу төрийн албан хаагчдыг тасралтгүй сургах, төр иргэний нийгмийн байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, үндэсний хэмжээнд удирдахуйн ухааны зангилаа асуудлаар судалгааны ажил хийх, судалгаанд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, зөвлөх үйлчилгээг өргөжүүлэх, агуулга хүртээмжийг нэмэгдүүлэх , удирдлагын үйл ажиллагааг сайжруулах ТӨААТГазрын статустай ажилладаг юм. Ийнхүү ажиллахдаа Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 55 дугаар тогтоолын дагуу өөрийгөө санхүүжүүлэн ажиллах зарчимд нийцүүлэн төлөвлөж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн ажилласан болно.

Удирдлагын Академи нь ЗГХЭГ-аас жил бүрийн захиалгаар гүйцэтгэх сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний ажлын төлөвлөгөөг баталж төлөвлөгөөний дагуу төсвийн санхүүжилтийг нь олгож ажилладаг байна.

"Удирдлагын Академи" нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. ХХБанкны Богд-Хан салбар банктай харьцдаг.

"Удирдлагын Академи"-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар "Удирдлагын Академи"-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого зардлын дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5-1/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 9-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад "Удирдлагын Академи"-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан "Удирдлагын Академи"-ийн захирлын тушаалаар батлуулан 2014 оноос эхлэн мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь НББ-ийн тухай хууль, НББОУС, СТОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програмтай байна.

"Удирдлагын Академи"-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

"Удирдлагын Академи"-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн "Unicus" програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**<u>Материаллаг байдал:</u>**

Төлөвлөлтийн үе шатанд материаллагын түвшинг тогтоохдоо суурь оны жилийн нийт урсгал зардлын санхүүжилтийн дүнгээс 1%-иар бодож 41,5 сая төгрөгөөр тооцож байсан. Харин гүйцэтгэлийн үе шатанд үйл ажиллагааны нийт орлогоос 1%-иар дахин тооцоход 49,4 сая төгрөг болж төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллагын түвшин 7,8 сая төгрөгөөр нэмэгдэж байгаа учраас дахин тооцоолол хийх шаардлагагүй байна.

**<u>Дотоод хяналт:</u>**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. "Удирдлагын Академи"-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна."Удирдлагын Академи" нь дотоод хяналтын нэгжгүй, төсвийн ерөнхийлөн захирагч ЗГХЭГ-ын дотоод аудитын нэгжээс байнга хяналт тавьдаг мөн байнгын ажиллагаатай "Захиргааны зөвлөл" ажилладаг байна.

**<u>Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар</u>:**

2016 онд "Удирдлагын Академи" нь өөрийн орлогоор санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхээс гадна ЗГХЭГ-аас засгийн газрын захиалгат сургал, судалгааны ажлын санхүүжилт авч нийт 4454,8 сая төгрөгийн батлагдсан төсөвтэйгээр ажилласнаас тайлант хугацаанд 4956,7 сая төгрөгийн орлоготой, 4446,2 сая төгрөгийн мөнгөн зарлагын гүйцэтгэлтэй ажилласан байна. Нийт орлогын 1032,4 сая төгрөг буюу 20,8 хувийг ЗГХЭГ-ын урсгал төсвийн санхүүжилтээр, 17,3 сая төгрөг буюу 0,3 хувийг сургалтын төрийн санхүүжилтээр, 3907,1 сая төгрөг буюу 78,9 хувийг үндсэн үйл

ажиллагааны орлогоор тус тус бүрдүүлсэн байна. Тайлангийн жилийн эцэст харилцах дансны үлдэгдэл 3412,3 сая төгрөг байна. Нийт үйл ажиллагааны зардлын 50,5%-ийг цалин НДШ-ийн зардалд, 5,4%-ийг ашиглалтын зардалд, 13,4%-ийг ЭШ болон хичээл сургалтын зардалд, 10%-ийг урсгал зардалд, 2,0%-ийг тэтгэвэр тэтгэмж, урамшуулалын зардалд тус тус зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг сар, улирлын хуваариар гаргаж биелэлтийг тооцож гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

**<u>Шилэн дансны мэдээлэл</u>**

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгууллагын вэб хуудсанд нээсэн ЗГХЭГ-ын хэрэгжүүлэгч агентлагийн "Шилэн цонх" сайтад төсвийн гүйцэтгэлийн тайланг 12 удаа, бусад мэдээллийг тухай бүр нь үнэн зөв, бодитой, тогтмол байршуулж хэвшсэн байна.

**<u>Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:</u>**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын 26 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

<u>Үр дагаварыг тодорхойлж чадвал:</u>

Аудитын гүйцэтгэлийн ажлын явцад хэрэгжүүлсэн 9 сорилоос 1 сорил нь холбогдох санхүүгийн холбогдох батламж мэдэгдлүүдийг хангахгүй байв.

Удирдлагын Академийн сонсогч, суралцагч нь өөрийн суралцсан хугацаа, судалсан кредитийн зөрүү, төлбөрийн тооцооны талаарх мэдээллийг авах, харах бололцоо байдаггүй.

**<u>Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:</u>**

"Удирдлагын Академи"-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, бараа материал, хөрөнгийн элэгдэл, үндсэн хөрөнгө, бусад орлого, авлага, өглөгийн дансуудад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Үүнд:

<u>Мөнгөн хөрөнгийн дансны сорилоор:</u> Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2901,8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3412,3 сая төгрөг байгаа нь харилцах дансны банкны үлдэгдлийн баталгаа, мөнгөн хөрөнгийн журналын дүнтэй тохирч байна. "Удирдлагын Академи"-ын хичээлийн жил, санхүүгийн жилийн зөрүүтэй хугацаанаас хамаарч банкин дахь харилцах данс, УОО дансны үлдэгдэл ихтэй тайлагнадаг онцлогтой бүртгэл хөтлөлт байна.

Үндсэн хөрөнгийн дансны сорилоор:Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7452,9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7617,9 сая төгрөг байгаа нь хөрөнгийн тооллогын бүртгэл, үндсэн хөрөнгийн журналын үлдэгдэлтэй тохирч байна. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 165,0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч орлогоор бүртгэж тайлагнасан байна. Тус байгууллага нь сургалтын зориулалттай хөрөнгө бэлтгэх үүрэгтэй бөгөөд үүнийгээ хэрэгжүүлэхдээ батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэдэг байна. Оны эхний хуримтлагдсан элэгдэл 5280,4 сая төгрөг байсан бол тайлант жилд 638,8 сая төгрөгийн элэгдэл байгуулж хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл 5919,2 сая төгрөг болж цэвэр хөрөнгийн 1698,7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Цэвэр хөрөнгийн дүн нь санхүүгийн байдлын тайланд, хөрөнгийн орлого нь мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгийн зардлаар, тайланд онд байгуулсан элэгдэл нь санхүүгийн үр дүнгийн тайланд үнэн зөв тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны сорилоор:Бараа материалын дансны эхний үлдэгдэл 40,5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 52,4 сая төгрөг байгаа нь бараа материалын тооллогын бүртгэлтэй тохирч байна. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 115,0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдан авч 103,0 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Тайлант онд хандив тусламжаар ирсэн болон акталж, устгасан бараа материал байхгүй байна.

Орлогын дансны сорилоор: Улсын төсвөөс 1032,4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3324,1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 478,5 сая төгрөг, Сургалтын төрийн сангаас 17,3 сая төгрөг нийт 4852,3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Урьдчилж орсон орлого дансны сорилоор: 2016 онд 3409 хүнд төрийн менежментээр мэргэшүүлэх "улирал,гараг-зайн"сургалт, бусад сургалтанд зориулсан 1032,4 сая төгрөгийн төсвийн санхүүжүүлтийг УОО дансанд бүртгэж байгаад, сургалтын дуусгавар болсон хугацаагаар нь хэрэгжилтийг нь хүлээн зөвшөөрч орлого, зардлаар бүртгэж тайлагнадаг байна. Үндсэн үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор тайлант хугацааны эцэст нийт 1691.9 сая төгрөгийн сургалтын болон байрны төлбөрийн урьдчилж орсон орлого бүртгэгджээ. ЗГХЭГ-аас сургалтын зардлыг тооцохдоо кредитийн үнийн 60%-иар тооцож санхүүжүүлдэг байна. Удирдлагын Академийн санхүү нь УОО данснаас тухайн хичээлийн жилд суралцаж төгссөн сонсогч, суралцагчийн тоо болон хугацаатай уялдуулж үйл ажиллагааныхаа орлого, зардлыг хүлээн зөвшөөрсөн бичилтийг хийж тайлагнадаг. Харин орлого, зардлыг сонсогч, суралцагч тус бүрээр суралцсан хугацаа, судалсан кредитд үндэслэн бодитой тооцдоггүй байна. Иймээс суралцсан хугацаа, судалсан кредитийн тооцоог үндэслэн орлогыг хуваариладаг сургалтын төлбөрийн, санхүүгийн програм хангамжийг сайжруулах шаардлагатай байна.

Авлагын дансны сорилоор:Оны эхний үлдэгдэл 984,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 975,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 9,4 сая төгрөгөөр буурсан байна.Нийт авлагын 96,5% буюу 950,1 сая төгрөг нь Сангийн яамны Төрийн санд төвлөрүүлсэн харилцах дансны үлдэгдэл авлага эзэлдэг байна. Үлдэх 25,3 сая төгрөгийн авлага нь тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Өглөгийн дансны сорилоор:Оны эхний үлдэгдэл 55,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 64,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 8,4 сая төгрөгөөр

нэмэгдсэн байна. Өглөгийн үлдэгдлийг бүтцээр нь авч үзвэл 38,7% буюу 24,8 сая төгрөг нь ШУТСангийн захиалгаар хийгдэж байгаа судалгааны ажлын тайлагнаагүй санхүүжилтийн өглөг, 0,9% буюу 0,5 сая төгрөг нь хувь хүн, 60,4% буюу 38,8 сая төгрөг нь ажил үйлчилгээ худалдан авалттай холбоотой 13 компанийн барьцаа өглөг байна. Өглөгийн үлдэгдэл нь өглөгийн журналын үлдэгдэлтэй тохирч аудитын О, Ү, Ө, Тол илч гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаж байна.

Зардлын дансны сорилоор: Гэрэл цахилгааны зардал 1,1 сая төгрөгөөр,цэвэр бохир усны зардал 8,8 сая төгрөгөөр тус тус хэтэрснийг халаалтын зардлын хэмнэлтээс шилжүүлэн зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлээс харахад төсвөөс хэтэрсэн зардал байхгүй гүйцэтгэлд сайн хяналт тавьж ажилласан байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

УОО дансны орлого, зардлыг хүлээн зөвшөөрөхдөө сонсогч, суралцагч бүрээр суралцсан хугацаа, судалсан кредитд үндэслэн бодитой тооцдоггүй байна. Иймээс суралцсан хугацаа, судалсан кредитийн тооцоог үндэслэн орлогыг хуваариладаг сургалтын төлбөрийн, санхүүгийн програм хангамжийг сайжруулах шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д" Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно " гэж заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

**Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад 2016 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

**Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Эрсдэлтэй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

"Удирдлагын Академи"-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар УОО дансны бүртгэлийн бичилттэй холбоотой програм хангамжийг сайжруулах талаар зөвлөмж өгч ажиллалаа.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт 100%-ийн биелэлттэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

"Удирдлагын Академи"-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА**
**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ**

**АУДИТЫН МЕНЕЖЕР Я.САМБУУНЯМ**

**БЭЛТГЭСЭН:**
**АУДИТОР Э.ЭРДЭНЭБАТ**

## ЗГХЭГ-ын харьяа
## "Удирдлагын Академи" -ийн
## 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# Менежментийн захидал

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**


Асуудал 1
УОО данс.....................................................3


**2016 оны 2 дугаар сар**

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг "Удирдлагын Академи"-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно.

Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь  санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллагаас гаргасан энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан "Удирлагын Академи"-ийн санхүүгийн  холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

| Асуудал 1: Зардал | Тэргүүлэх ач холбогдол №2 |
|---|---|

**<u>ҮАГ-ын ажиглалт</u>**

УОО дансны орлого, зардлыг хүлээн зөвшөөрөхдөө сонсогч, суралцагч бүрээр суралцсан хугацаа, судалсан кредитд үндэслэн бодитой тооцдоггүй байна.

**<u>ҮАГ-ын зөвлөмж</u>**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-д заасныг хэрэгжүүлж сонсогч, суралцагчийн суралцсан хугацаа, судалсан кредитийн тооцоог үндэслэн орлогыг хуваариладаг сургалтын төлбөрийн, санхүүгийн програм хангамжийг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

**<u>Эрсдэлүүд</u>**

Сонсогч, суралцагч нь өөрийн суралцсан хугацаа, судалсан кредитийн зөрүү, төлбөрийн тооцооны талаарх мэдээллийг авах, харах бололцоо байдаггүй.

**<u>Төсвийн захирагчийн хариу</u>**

Зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах болно

.23.*Удирдлагын болон чанарын дахин хяналт:*

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

**Аудитыннэр:** "Удирдлагы Академи"-ийн 2016 оны санхүүгийн тайлан

**Аудитынкод:** ҮАГ-САГ/2017/2/СТА-ГАК-ТШЗ

**Аудитын багийн нэр:**"Ньюдиил Аудит" ХХК

**Тайлант жил :**2016 он

| № | Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр | Хяналтхийсэногноо | | Тайлбар |
|---|---|---|---|---|
| | | Анхан шатны хяналт | Хоёр дах шатны хяналт | |
| 1 | Аудитын тайлан | ✓ | ✓ | |
| 2 | Санхүүгийн аудитын газрын тэргүүлэх /аудитороор гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн **Аудитынгэрчилгээ** | ✓ | ✓ | |
| 3 | Менежментийн захидал | ✓ | ✓ | |
| 4 | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, | ✓ | ✓ | |
| 5 | Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан | ✓ | ✓ | |
| 6 | Акт, албаншаардлагын төсөл | | | |
| 7 | Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт | | | Байхгүй |

Бэлтгэсэн: Аудитор Э.Эрдэнэбат

Анхан шатны хяналт хийсэн:
Аудитын менежер: Я.САМБУУНЯМ

Хоёр дах шатны хяналт хийсэн:
САГ-ындаргаТэргүүлэхаудитор: Ц.НАРАНЧИМЭГ

**ЗГХЭГ-ЫН ХАРЬЯА УДИРДЛАГЫН АКАДЕМИ**
**2016 ОНЫ АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

### тєгрєгєєр

| № | | | БАЛАНСЫН ЗҮЙЛ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| 3.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | | | 2901813301.84 | 3412328748.94 |
| | | Кассад байгаа бэлэн мөнгө | | | |
| | | Төсвийн харилцах | | | |
| 3.3 | Авлага | | | 984785216.14 | 975359219.64 |
| | | Татаас ба санхүүжилтийн орлого | | | |
| | | Төлбөртэй үйлчилгээний авлага | | | |
| | | Бусад авалга | | | |
| 3.4 | Урьдчилгаа | | | | |
| | | Урьдчилж гарсан зардал | | | |
| 3.5 | Бараа материал | Тусгай зориулалттай материал | | 11614460.00 | 10855610.00 |
| | | Эм боох материал | | 0.00 | 0.00 |
| | | Дуусаагүй үйлдвэрлэл | | 0.00 | 0.00 |
| | | Бэлэн бүтээгдэхүүн | | 0.00 | 0.00 |
| | | Бичиг хэргийн материал | | 14285600.01 | 25551725.00 |
| | | Аж ахуйн материал | | 1251040.00 | 1655880.00 |
| | | Сэлбэг хэрэгсэл | | 0.00 | 0.00 |
| | | Түлш, шатах тослох материал | | 0.00 | 0.00 |
| | | Барилгын засварын материал | | 0.00 | 0.00 |
| | | Хүнсний материал | | 420464.00 | 0.00 |
| | | Малын тэжээл | | 0.00 | 0.00 |
| | | Баглаа боодол | | 0.00 | 0.00 |
| | | Бусад хангамжийн материал | | 5995998.00 | 9334358.00 |
| | | Мал амьтад | | 0.00 | 0.00 |
| | | Нөөцийн бараа | | 6906341.34 | 5038341.34 |
| | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | | **3927072421.33** | **4440123882.92** |
| 3.9 | Үндсэн хөрөнгө | Барилга байгууламж | | 5741577332.16 | 5741577332.16 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -4637160625.68 | -4666409507.04 |
| | | Авто тээврийн хэрэгсэл | | 43834120.00 | 43834120.00 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -43834119.92 | -43834120.00 |
| | | Тоног төхөөрөмж | | 527326843.52 | 553254433.52 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -378427168.72 | -436968142.25 |
| | | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 359790888.26 | 402756688.26 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -173994708.47 | -209399672.06 |
| | | Зам гүүрийн барилга байгууламж | | 0.00 | 0.00 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| | | Батлан хамгаалах зориулалттай тоног төхөөрөмж | | 0.00 | 0.00 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | | |
| | | Түүх соёлын дурсгалт зүйлс | | 0.00 | 0.00 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| | | Дуусаагүй барилга | | 0.00 | 0.00 |
| | | Бусад үндсэн хөрөнгө | | 75283501.57 | 160983061.57 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -21298444.00 | -25781004.32 |
| | | Програм хангамж | | 31654150.00 | 36310230.00 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -7811375.04 | -18899319.97 |
| | | Бусад биет бус хөрөнгө | | 517892000.00 | 517892000.00 |
| | | | хуримтлагдсан элэгдэл | -17892000.00 | -517892000.00 |
| | | Номын фонд | | 155517648.18 | 161255048.18 |
| | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | | **2172458041.86** | **1698679148.05** |
| | **НИЙТХӨРӨНГИЙН ДҮН** | | | **6099530463.19** | **6138803030.97** |
| 4.1 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | | | |
| | Богино хугацаат зээл | | | | |
| | | Өглөг | | 55686576.00 | 64122027.00 |
| | | Урьдчилгаа-төсвийн татаас | | 1751173600.00 | 1691910000.00 |
| | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | | **1806860176.00** | **1756032027.00** |
| | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | | | |
| | **ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | | **1806860176.00** | **1756032027.00** |
| | Эзний өмч | Засгийн газрын оруулсан капитал | | | |
| | | Орон нутгийн сан | | 2160774482.44 | 2160774482.44 |
| | | Хуримтлагдсан үр дүн | | 2131895804.75 | 2221996521.53 |
| | | | Өмнөх үеийн үр дүн | 2131895804.75 | 2131895804.75 |
| | | | Тайлант үеийн үр дүн | | 90100716.78 |
| | | Дахин үнэлгээний сан | | 0.00 | 0.00 |
| | **ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН** | | | 4292670287.19 | 4382771003.97 |
| | **ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН** | | | 6099530463.19 | 6138803030.97 |
| | Нийт хөрөнгө - өр төлбөр, эздийн өмчийн зөрүү | | | 0.00 | 0.00 |

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР Э.ЭРДЭНЭБАТ

АУДИТОРЫН ТУСЛАХ Э.ЭРХЭМБАР

ЗГХЭГ-ЫН ХАРЬЯА" УДИРЛАГЫН АКАДЕМИ"

# МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

####

| № | | | Үзүүлэлт | Аудитлагдаагүй Мөнгөн гүйлгээ | Аудитлагдаагүй Үр дүн | Аудитлагдсан Мөнгөн гүйлгээ | Аудитлагдсан Үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Татаас,санхүүжилтийн орлого | | Төвлөрсөн төсвөөс | 1032350000 | 1032350000 | 1032350000 | 1032350000 |
| 2 | | | Орон нутгийн төсвөөс | | | | |
| 3 | | | Хөрөнгийн | | | | |
| 4 | | | үр дүнгийн урамшуулал | | | | |
| 5 | | | Бусад тусгай зориулалтын сангаас | | | | |
| 6 | Тусламжийн орлого | | ОУ-ын байгууллагын тусламж | | | | |
| 7 | | | Төсөвт байгууллагаас | | | | |
| 8 | | | нэмэлт данс | 17303050.00 | 17303050.00 | 17303050.00 | 17303050.00 |
| 9 | Бэлгийн өмчтэй холбоотой | | үнэ төлбөргүй авсан бараа материал | | | | |
| 10 | | | Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө | | | | |
